

ОРХОН АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Захиргаа, удирдлагын хэлтэс
Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Б.Батжаргал, Утас: 94209421

2024.11.04

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

№	ЗОРИЛТ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ ХШҮ (хувь)
							Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА											
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орон сууцанд амьдрах боломжийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг тэлэн амьдралын чанарыг дээшлүүлнэ.											
Зорилт 3.4 Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ:											
1	3.4.6.Хоршоо эрхлэгчдийг бодлогоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2020-2025	ХБТХО Х, ХХААГ	Орон нутгийн төсөв	10.0	-	Хоршоо эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлсэн байна.	20.0	ХХСан 250.0 Шинэ хоршоо хөдөлгөөн 4,937.2	Аймгийн хэмжээнд мал аж ахуй, газар тариалан, худалдаа, нийтийн тээвэр, оёдлын чиглэлээр 62 хоршоо бүртгэлтэй байдгаас тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 13 хоршоо байна. 2022 онд мал аж ахуйн чиглэлийн “Арга билиг арвин сүрэг” хоршоо, 2023 онд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Арвин сүргийн өгөөж” хоршоо шинээр байгуулагдсан. Арга билиг арвин сүрэг хоршоо нь Оюут багт өөрийн нэрийн дэлгүүрээ нээн 10 гаруй нэр төрлийн цагаан идээгээр иргэдэд үйлчилж байна. "Арга	100

										билиг Арвин сүрэг" хоршооны технологичийг ӨМӨЗО-д туршлага судлахад дэмжлэг үзүүлсэн. Энэ хоршоо нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн PROGRES төслөөс 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн, "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд сүү сүүн бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Ингэснээр үйл ажиллагаагаа өргөжүүлж 9 ажлын байр шинээр нэмэгдсэн. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай” А/194 дүгээр захирамжаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт 11 арга хэмжээ зохион байгуулахаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу: 1.Хоршоодыг чадавхжуулах 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 170 хүнийг хамруулсан. 2."Хоршоог хөгжүүлэх сан"-аас хөдөө аж ахуйн чиглэлийн 3 хоршоо 250 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 28 ажлын байр хадгалагдаж, 5 ажлын байр шинээр нэмэгдсэн байна. 3.Туршлага судлах аялалд нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй оролцож Булган, Хөвсгөл аймгийн 12 үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцав. 4.Хоршоологчдын улсын зөвлөгөөнд 15 хоршооны төлөөлөл амжилттай оролцож спортын бага наадамд ширээний теннисийн төрөлд 2-р байр эзэлсэн. 5."Шинэ хөдөө- үйлдвэрлэгч өрх" төслийн хүрээнд сүү савлагч тоног төхөөрөмжийг мал аж	
--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									ахуйн чиглэлийн Арга билиг арвин сүрэг хоршоо, Хушт булуу хоршоонд гэрээгээр эзэмшүүлж дэмжлэг үзүүлсэн. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд: 1.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий нээлтийн арга хэмжээ Орхон аймгийн 72 төлөөлөгч оролцсон. Тус арга хэмжээ Улаанбаатар хот Дунд гол дахь UJ Arena төвд зохион байгуулагдсан бөгөөд 21 аймгийн 300 сумын 3100 гаруй төлөөлөгч оролцож “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий зорилго, хоршоонд нэгдэхийн ач холбогдол, хоршоо байгуулах, бүртгүүлэх, хэрхэн элсэх талаар зөвлөмж, хоршооны сайн туршлагуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан. 2.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий Хойд бүсийн нээлтийн арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 06-нд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Спорт цогцолборт зохион байгуулагдав. Тус нээлтийн арга хэмжээнд Орхон, Хөвсгөл, Булган аймгийн нийт 1402 малчин оролцсон. 3.Сурталчлан таниулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээлэл хүргэх, зөвлөн туслах үйлчилгээг сумдын 620 малчинд мэдээлэл өгсөн. 4.Хөдөө аж ахуйн чиглэлийн 35 хоршоо /375 гишүүн/ шинээр байгуулагдсан. 5.Аймгийн хэмжээнд мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлийн 30 хоршоо 4.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 6. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 30 хоршооны 103 малчин өрхийн үйл ажиллагаатай танилцаж мониторинг хийхэд: •18 өрх 54 техник тоног төхөөрөмж /трактор, хадуур, тармуур, өвс пресслэгч/	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										•1 хоршоо ажлын байрны зориулалттай хашаа байшин •1 хоршоо худаг гаргасан •2 хоршоо мах сүүний хөргүүр барьсан •10 малчин өрх 10 хашаа саравч •63 малчин өрх 3586 толгой мал худалдаж авч зориулалтын дагуу ашигласан байна. 7.Малчдын хоршоонд эрчимжсэн мал аж ахуйн фермерийн зориулалтаар 3 хоршоонд газар эзэмшүүлсэн. Үүнд: Долоон хайлаастайд 2.58га – Хөлгийн өвөр хөндлөн хоршоо Шувуутад 3,77 га- Шонхорын хүч хоршоо Хөшөөтөд 4.62 га- Арга билиг арвин сүрэг хоршоод газар олгогдсон.	
2	3.4.7.Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөрт хамрагдах, санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	НБХ ХБТХОХ ХХААГ	Улсын төсөв	15917.0	-	Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлд зээл олгох замаар дэмжиж санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	3600.0	ЖДҮС-1,272.0 Хоршоо хөгжүүлэх сан 250.0 ХААҮДС 900.0 Шинэ хороо хөдөлгөөн 4,937.2 Тусгай сан 265.8	2021-2022 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 аж ахуйн нэгжид 3.1 тэрбум, 53 иргэнд 1.2 тэрбум буюу нийт 4.3 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1 аж ахуйн нэгжид 94.3 сая төгрөг, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1 аж ахуйн нэгж хамрагдаж 50.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгож 33 ажлын байр хадгалагдаж, 4 ажлын байр шинээр нэмэгдсэн. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас журмын шаардлага хангасан 5 төсөлд 894.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Хөдөлмөр	100

										эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журмын дагуу зээлийн өмнөх сургалтыг Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулсан. Банкаар судлагдсан иргэдээс 11 иргэн дэмжигдэж 290.0 сая төгрөгийн санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Төрийн банкаар дамжуулан олгож, 12 ажлын байр хадгалагдан шинээр 15 ажлын байр бий болсон. 2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоо 4,937.2 сая төгрөг, нийт 55 шинэ ажлын байр нэмэгдсэн. Аймгийн Өрхийн болон ЖДҮ эрхлэгчдийн дэмжих тусгай сангаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөг, нийт 43 аж ахуйн нэгж, 7 иргэнд 7,625.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон.	
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ											
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, олон тулгуурт эдийн засагтай хот болно.											
Зорилт 4.1. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:											
3	4.1.1.Экспорт од чиглэсэн бизнест эрх зүйн хувьд зөвшөөрөгдсөн, боломжит дэмжлэгүүдийг үзүүлж, хөдөө аж ахуйн	2020-2025	ХБТХОХ	-	-	2 аж ахуйн нэгжийн 13300 ширхэг бараа,	3 нэр төрлийн бүтээгдэхүүн экспорт л оно. (арьс	-	-	2022 онд нийт 12 аж ахуйн нэгжийн 29 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тохирлын баталгаажуулалтад хамруулан, тохирлын гэрчилгээ олгож 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортлоход тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон гадаад худалдааны үйл ажиллагааг нь дэмжсэн 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нийт 17 үйлдвэрийн 11 нь буюу 64.7 хувь	100

бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.					бүтээгдэхүүн экспортод гаргасан.	шир, ноос ноолуур, мах)			баталгаажуулалтад хамрагдаж 26 нэрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж баталгаажуулсан. “Эрдэнэт хивс” ХХК, “Эрдэнэт кашмер” ХХК-ийн 4 нэр төрлийн 13 нэрийн бүтээгдэхүүн, мал төхөөрөх, мах боловсруулах 4 үйлдвэрийн 3 нэрийн бүтээгдэхүүн баталгаажуулалтад хамрагдан, тохирлын гэрчилгээ авч бүтээгдэхүүнээ экспортлож байна. Аймгийн хэмжээнд 4 үйлдвэрийн 16 нэрийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах тухай бүрд нь тохирлын баталгаажуулалтад хамруулан гэрчилгээжүүлж, гадаад худалдааг хөнгөвчилж байна. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 35.2 хувийг экспортод гаргаж байна. 2024 онд “Эрдэнэт кашмер” ХХК технологийн шинэчлэл хийснээр жилдээ 4400 тн ноос угаах хүчин чадалтай болж өргөжсөн нь өмнөхөөс 2.5 дахин илүү хүчин чадалтай болж, гэр ахуйн хэрэглээний оёмол бүтээгдэхүүн, ноолуур болон ноосон бэлэн хувцсыг үйлдвэрлэж бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлсэн. Мөн тус компанийн сүлжмэлийн үйлдвэрт Герман улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж суурилуулж хүчин чадлаа нэмэгдүүлснээр сүлжмэл хувцасны үйлдвэр жилд 11000 ширхэг цамц, оёдлын үйлдвэр нь жилд 90000 ширхэг оёмол бүтээгдэхүүн, нэхмэлийн үйлдвэр нь жилд дунджаар 50000 метр тэмээ, хонь, сарлагийн ноос, хөөврөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж ОХУ, Европын холбооны орнуудад экспортолж байна. Эрдэнэт хивс ХХК-аас ноолуурын угаах цехэд 2 төрлийн сэгсрэх машин суурилуулснаар хог хаягдлыг хуурайгаар нь ачиж зайлуулдаг болсноор лагийн хэмжээ буурсан.	
---	--	--	--	--	----------------------------------	-------------------------	--	--	--	--

										Ажлын гутал, эсгий табчик хийдэг "Мөнх баян алт" ХХК нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төсөлд хамрагдаж тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийснээр гар ажиллагааг 40-50 хувь хөнгөвчилж ажлын бүтээмж нэмэгдэн, жилд дунджаар 2500–3000 хос эсгий табчик үйлдвэрлэн ОХУ руу экспортолж байна.	
4	4.1.8.Орон нутгийн импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал, санаачилгыг бүх талаар дэмжинэ.	2020-2025	ХБТХО Х, ХХААГ	ОНТ	5.0	-	Импорт ыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачилгыг дэмжих	-	Улсын төсөв 900.0	Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих Прогресс төслийн брэндийн сургалтад хамрагдаж шалгарсан аж ахуйн нэгжүүдэд тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: “Баяжуулагч Одод” ХХК хатаасан аарц үйлдвэрлэл, “Цэцээ-Өндөрлөг” ХХК савхин эдлэл, Арга билэг Арвин сүрэг хоршоо нь “Бэлгийн багц”, Үлэмж нандин ХХК Care kids гэсэн чиглэлээр брэнд бий болгохоор ажиллаж байна. “ITM Mongolia 2023” арга хэмжээнд орон нутгийн арьсан эдлэлийн Өндөрлөг брэнд, гар урлалын Сампин брэнд бүтээгдэхүүнийг оролцуулан үйл ажиллагааг дэмжсэн. Хөгжлийн Шийдэл ТББ-н “BEST” хөтөлбөрөөс “БҮТЭЭЛЧ CEO” сургалт зохион байгуулж нийт 12 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, бүтээгдэхүүнийг хэрхэн хөгжүүлж брэнд бий болгох талаар санал солилцож, хэлэлцүүлэг зохион байгуулсан. “Эрдэнэт хивс”, “Эрдэнэт кашмер” ХХК-ийн 4 нэр төрлийн 13 нэрийн бүтээгдэхүүн баталгаажуулалтад хамрагдан, тохирлын гэрчилгээ авч бүтээгдэхүүнээ экспортлож байна. 2024 онд Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хүүгийн хөнгөлөлттэй	100

									зээлд хүнс, худалдааны чиглэлийн 6 аж ахуйн нэгжийн 3.7 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтийг дэмжин Хүнс, хөдөө аж ахуйн яаманд уламжилснаас эргэлтийн хөрөнгийн 200.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 700.0 сая төгрөг, нийт 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөгийн зээл авч, хиаман төрлийн бүтээгдэхүүн, талхны нэр төрөл 3 аар нэмэгдэж, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдэх боломж бүрдсэн. Best хөтөлбөртэй хамтран “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн Ногоон бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрийн сургалт 1, Хүнсчдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх, үйлдвэрлэгчийг чадавхжуулах уулзалт, сургалт 2, нийт 3 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 89 үйлдвэрлэгчийг хамруулан зах зээлд суурилсан эко шошгожуулалт, ногоон баталгаажуулалтын системийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн тэдний дадал, зан төлөвөө өөрчлөн чадавхжих сургалтаар хангаж, ногоон санхүүжилтийн эх үүсвэртэй болгох замаар тойрог эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлэн ажилласан. Урлахуйн жигүүр ХХК, Өндөрлөг брэнд, Ширмэг цүнх ХХК, Сампин брэнд, Мөнх баян-Алт ХХК, Ачит Андаг ХХК-ууд импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Ачит Андаг ХХК артишокны цай болон эрүүл мэндийн 2 төрлийн ундаа үйлдвэрлэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Зэс Эрдэнэ ХХК-ийн ажилчдын хор саармагжуулах бүтээгдэхүүнээр нийлүүлж байна. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль-2024” арга хэмжээнд Орхон аймгийн 10 брэнд /Өндөрлөг брэнд, Сампин брэнд, Угалз брэнд, Жигүүр брэнд, цайны брэнд/ үйлдвэрлэгч иргэн аж ахуйн нэгж 80 гаруй нэр
--	--	--	--	--	--	--	--	--	--

										төрлийн импорт орлох бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцож 60 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн.	
Үндэсний баялгийн сан											
Зорилт 4.2. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжинэ:											
5	4.2.2.Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нь орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	-	-	-	Орон нутгийн аж ахуйн нэгжүүд ийн бараа бүтээгдэхүүнийг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэр ийн газар, компаниудад нийлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.	-	-	“Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөртэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТӨҮГ, томоохон аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд 2023 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 26 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчтэй 3.9 тэрбум төгрөгийн, 2 үйлдвэрлэгчтэй 2.8 тэрбум, ШШГЕГ-тай 2.7 тэрбум, нийт 9.5 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж ажилласан. “Ачит-Ихт” ХХК нь тайлант онд 105 иргэн, аж ахуйн нэгжээс 1.3 тэрбум төгрөгийн худалдан авалт, 92 аж ахуйн нэгж, иргэнээс 12.9 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ, “Эрдмин” ХХК нь 173 иргэн, аж ахуйн нэгжээс 1.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. “Баясгалант Бат-Очир” ХХК, “Үрт Ундрэм” ХХК, БЛГЯ хоршоо нь нийт 24 цэцэрлэг болон 16 сургуулийн үдийн хоолны ногоог гэрээгээр нийлүүлж, Эрүүл мэндийн байгууллага, хоол үйлдвэрлэлийн газарт 12 иргэн, 5 аж ахуйн нэгж өөрийн тариалсан төмс, хүнсний ногоог нийлүүлэн ажиллаж байна. Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулсан “Үндэсний үйлдвэрлэл-Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн арга хэмжээнд Жаргалант сумын 3 тариаланчийг дэмжин оролцуулсан. 2024 онд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад бараа, ажил,	100

										үйлчилгээ нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж зээл олгох, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн дэмжлэг үзүүлсний үр дүнд Урлахуйн жигүүр ХХК нь “Уран эгшиг” урлагийн сургуулийн 1200 хүүхдийн урлагийн хувцсыг урлан нийлүүлж байна. Уран хас ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдын ажлын хувцас, Гутал буян ХХК Ора металл ХХК-д ажлын 150 хос гутал, Мах маркет ХХК-д 20 хос гутал, Hard steel ХХК-д 20 хос гутал, Баяжуулагч-Одод ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хор саармагжуулах бүтээгдэхүүний 40 хувийг, аймгийн 32 сургууль, цэцэрлэгт сүү, сүүн бүтээгдэхүүн, Үржих таван эрдэнэ ХХК Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т дотор мах, дайвар бүтээгдэхүүн нийлүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад бараа бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа жижиг дунд үйлдвэрлэгчдийн тоо өмнөх оноос 20 хувиар нэмэгдсэн байна.	
НАЙМ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЭРДЭНЭТ ХОТ											
Зорилго 8. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой байдал, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан өвлүүлсэн, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвартай, тэнцвэртэй орон нутгийг хөгжүүлнэ.											
Өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй											
Зорилт 8.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:											
6	8.5.1.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.	2020-2025	ХБТХО Х, ХХААГ	Орон нутгийн төсөв	75.0	Хэрэгжилтийн хувь 30%	Хэрэгжилтийн хувь 100%	-	-	2022 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход малын махны 92.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 34.5 хувь, жимс, жимсгэнийн 0.3, төмсний 86.5 хувь, хүнсний ногооны 72 хувь, өндөгний 2.3 хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангасан бол шингэн сүүний 2.7 хувь, цагаан идээний 5.4 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангасан. "Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн" хөтөлбөр нь 2020-2021 онд 85.0 хувийн гүйцэтгэлтэй	80%

									хэрэгжсэн бөгөөд Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулж, шаардагдах 52.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлснээр 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн, 1 арга хэмжээ хэрэгжилтийн шатанд, 3 арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаа хүлээгдэж байна. Аймгийн хэмжээнд мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхээр нийт 58 аж ахуйн нэгж, иргэн бүртгэгдсэнээс мах, махан бүтээгдэхүүний 10, гурил, малын тэжээлийн 5, сүү, сүүн бүтээгдэхүүний 4, гурилан бүтээгдэхүүний 24, ургамлын цайны 1, нөөшилсөн ногооны 4, нийт 49 цех болон үйлдвэрүүд байна. Эдгээрээс тохирлын гэрчилгээтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа гурил, тэжээл үйлдвэрлэгч 3, мах, махан бүтээгдэхүүний 5, сүү, сүүн бүтээгдэхүүний 2, гурилан бүтээгдэхүүний 14, ургамлын цайны 1, нийт 26 цех болон үйлдвэрүүд байгаа бөгөөд нийт үйлдвэрлэл эрхлэгчдийн 53 хувь нь тохирлын баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. 2023 оны байдлаар аймгийн хүн амын хэрэгцээт малын махны 60.2, сүүний 4.0, цагаан идээний 4.6, гурилан бүтээгдэхүүний 42.6, улаан буудай 100.0, төмсний 43.3, хүнсний ногоо 100.0 хувь тус тус орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. 2024 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход малын мах-3758.8 тн, сүү-5011.7 тн, цагаан идээ-	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										5638.2 тн, гурил-3132.3 тн, гурилан бүтээгдэхүүн-5638.2 тн, төмс-3758.8 тн, хүнсний ногоо-8144.0 тн, жимс-6264.6 тн, өндөг-626.5 тн хэрэгцээтэй. 2023 онд хүнсний боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарын чиглэлээр давхардсан тоогоор 12 аж ахуйн нэгж, байгууллага, 3 тэрбум 49 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаагаа өргөжүүлснээр аймгийн боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 15.8 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт эзэлж, 35.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 59.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 3.6, борлуулалт 48.2 хувиар тус тус өссөн байна. 2023 оны аймгийн хүн амын жилийн хэрэгцээ: малын мах-3758.7 тн, сүү-5011.6 мян.л, цагаан идээ-5638 тн, гурил-3132.2 тн, гурилан бүтээгдэхүүн-5638 тн, төрөл бүрийн будаа-1566.1 тн, сахар, чихрийн зүйл-1033.2 тн, төмс-3758.7 тн, хүнсний ногоо-8143.8 тн, жимс-6264.5 тн, ургамлын тос-720 тн, цөцгийн тос-313.2 тн, өндөг-626.4 тн буюу 13 сая 243 мянган ширхэг. 2023 оны статистикийн жинхэнэ гүйцэтгэлээр үхрийн мах 877.8 тн, хонины мах 1074.9 тн, адууны мах 114.8 тн, ямааны мах 59.1 тн, дайвар бүтээгдэхүүн 599.5 тн, хиамагны зүйл 110.2 тн, боловсруулсан шингэн сүү 246.5 мян.л, тараг 81.7 мян.л, зайрмаг 400.6 мян.ш, нарийн боов 1414.3 тн, бялуу 201.2 тн, хэвийн боов 13.3 тн, талх 745.4 тн, гоймон 190.2 тн, хэрчсэн гурил 445.1 тн, бууз, банш 84.3 тн, хийжүүлсэн цэвэр ус, рашаан 2031.3 мян.л, ундаа, жүүс 4.2 мян.л-ийг үйлдвэрлэж, өмнөх оны мөн үеэс хонины мах 20.0, хиамаг 15.8, боловсруулсан шингэн сүү 8.5,	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										зайрмаг 20.2, нарийн боов 6.6, талх 25.8, хэрчсэн гурил 57.8, гоймон 77.8, бууз банш 25.3 хувиар тус тус үйлдвэрлэл өсөж, аймгийн хүн амын хэрэгцээт малын махны 83.0 хувь, сүүний 4.9 хувь, цагаан идээний 6.1 хувь, гурилан бүтээгдэхүүний 53.3 хувь, төмсний 43.3 хувь, хүнсний ногоог 100.0 хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангаж, сүү 0.4, сүүн бүтээгдэхүүн 0.5, гурил 4.5, гурилан бүтээгдэхүүн 11.5, хүнсний ногоо 10 хувиар хангамж өсөж, махны хангамж 17, төмсний хангамж 40.5, өндөгний хангамж 3 хувиар буурсан байна. 2024 онд үйлдвэр статистик мэдээнд хамрагдаж, 20.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 24.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалтыг хийж, аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 51.7 хувь, сүүний 8.0 хувь, цагаан идээний 7.7 хувь, гурилын 4.0 хувь, гурилан бүтээгдэхүүний 56.0 хувь, төмсний 48.0 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгний 1.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байгаа нь өмнөх оны мөн үеэс сүүний хангамж 4, цагаан идээ 3.1 хувиар, гурил 4 хувиар, гурилан бүтээгдэхүүн 15.2 хувиар, төмс 4.7 хувиар хангамж нэмэгдсэн.	
7	8.5.2.Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	Орон нутгийн төсөв	2.8	Талбайн ашиглалтын хувь 70	Талбайн ашиглалтын хувь 100	1.8	Орон нутгийн төсөв 1.8	2022 онд аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 86 хувь, хүнсний ногооны 72 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан. 2023 онд 5364 га талбайд тариалалт хийхээр төлөвлөснөөс 12 аж ахуйн нэгж, 563 өрх нийт 5584га талбайд тариалалт хийж, үүнээс үр тариа 3904 га, малын тэжээлийн ургамал 287, тосны ургамал 821га, төмс 146га, хүнсний ногоо 426га-д тариалж, уринш боловсруулалт 3600га талбайд хийж гүйцэтгэсэн. Ургац хураалтын	100

тогтворжуулан хөгжүүлнэ.									ажлыг 5612га талбайд хийж гүйцэтгэхээс 5612га талбайд хийж хураалтын ажил 100 хувь хийж гүйцэтгэсэн. Үр тариа 3904га талбайгаас 10892тн буюу га-аас 28цн ургац үүнээс улаан буудай 3805га талбайгаас 10752тн буюу 28цн ургац, төмс 145га талбайгаас 1628тн буюу га-аас 112цн ургац, хүнсний ногоо 455.2га талбайгаас 9520тн буюу га-аас 209цн, тэжээлийн ургамал 287га талбайгаас 1122тн буюу га-аас 39цн, тосны ургамал 821га талбайгаас 300тн буюу га-аас 3.7цн ургац тус тус хураан авсан. Ургацын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. Ургац хураалтад комбайн 15, хадагч /жатка/ 4, будаа цэвэрлэгч 8, үр сортлогч 5, будаа ачигч 7, төмсний комбайн 1, төмс, хүнсний ногоо ухагч 8, баталгаажуулсан электрон авто машины жин 3, механикжсан үтрэм 1, 11.0 мянган мкв талбай бүхий энгийн 5 үтрэм, 3700 тонн багтаамжтай 7 агуулах, 6548 тонн багтаамжтай 161 зоорь ажиллахаар бэлэн байдлыг ханган ажилласан. Улаан буудай борлуулалт: Гурилын үйлдвэр, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХК-д хүнсний буудай 8100 тонн, Улсын үрийн нөөц, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХК-д үрийн буудай 804 тонн, өөрийн үрийн нөөцөд 1042 тонн, малын тэжээлд 465 тонн тус тус нийлүүлсэн. Засаг даргын 2024 оны А/293 дугаар захирамжаар хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулах, тариалалтын чанарыг соёололтоор нь хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Газар
--------------------------	--	--	--	--	--	--	--	--	---

									тариалангийн үйлдвэрлэлийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Жаргалант сумын Агро үйлчилгээний төв нь 124 иргэний 102.2 га талбайг хагалах, 2 иргэний 2.3 га талбайд бууц цацах, 66 иргэний 38 га талбайд төмс тарих, 22 иргэний 21 га талбайд хүнсний ногоо тарих, 47 иргэний 28 га талбайн хөрс бутлах, 3 иргэний 6 га талбайд ургамал хамгааллын бодис цацах, 6 иргэний 12 га талбайд ногоон тэжээл тариалах нийт давхардсан тоогоор 270 иргэний 209.5 га талбайд үйлчилгээ үзүүлсэн бол ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд гарч иргэн, аж ахуйн нэгжийн захиалгаар өвс хадах, тармах, хаман боох, төмс хураахад давхардсан тоогоор 343 иргэний 335.3 га талбайд 4 төрлийн үйлчилгээг үзүүллээ. 2. Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрт Жаргалант сумын 500 өрхийг хамруулан үр олгож мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/257 дугаар тушаалаар төмс, хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлж, Орхон аймагт 7.5 тн үрийн төмс, 5.9 тн 10 төрлийн нарийн ногооны, нийт 13.4 тн үр хуваарилсан. Орон нутгийн тариаланчдад олгох ажлыг сумдын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгууллаа. 4. Жаргалант сумын 12 байршилд тариалангийн талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 5. Газар тариалангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдийг арга зүйгээр ханган ажилласан. Эдгээр ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 5113.6 га талбайд	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

										тариалалт хийхээр төлөвлөснөөс нийт 12 аж ахуйн нэгж, 393 өрх газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж, үр тариа 3841 га-д үүнээс 3723 га-д улаанбуудай, 118 га-д бусад үр тариа (вандуй, овъёос), 280 га-д малын тэжээл, 832 га-д тосны ургамал, 167 га-д төмс, 474 га-д хүнсний ногоо, нийт 5594 га-д тариалалт хийсэн. Ургац хураалт: Нийт 5594 га-д хураалт хийн, гүйцэтгэл 100 хувьтай байна. Үүнээс: 3841 га-аас 10097 тонн үр тариа, үүнээс 3723 га-аас 9890 тонн улаанбуудай, 167 га-аас 1941 тонн төмс, 474 га-аас 12149 тонн хүнсний ногоо, 832 га-аас 284 тонн тосны ургамал, 280 га-аас 1294 тонн тэжээлийн ургамал тус тус хураасан ба үр тариа 100 хувь, төмс 100 хувь, хүнсний ногооны 100 хувь, тосны ургамлын 100 хувь, тэжээлийн ургамал 100 хувьтай хураан авсан. Ургацын мэдээг долоо хоног бүр ХХААХҮЯ-д хүргүүлж байна.	
8	8.5.3.Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын	2020-2025	ХБТХО Х, ХХААГ	Орон нутгийн төсөв	6.0	17.3	20	-	Улсын төсөв 16.0	2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бог малын чанарыг сайжруулж, цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор “Манхан чүг” мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, мах, ноосны чиглэлийн Барга үүлдрийн хуц 60 толгой, ноолуурын чиглэлийн Эрчмийн хар үүлдрийн ухна 40, нийт 100 толгой хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьж, 2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын 70 малчинтай түрээсийн гэрээ байгуулан олгосон. 2023 онд аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж өмнөх оноос 27.0 хувиар өссөн байна. Үүнд: 30 иргэн мах, сүүний чиглэлийн 370 толгой үхэр, 11 иргэн махны чиглэлийн 414 толгой үхэр, 2 иргэн 269	100

хөгжлийг дэмжинэ.										толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 12 иргэн 590 толгой гахай, 78 иргэн 3195 толгой шувуу, 15 иргэн 329 бүл зөгий, 4 иргэн 96 толгой туулайг тус тус өсгөн үржүүлж байна. Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 4 иргэн хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн. "Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн"-д махны үхрийн аж ахуй эрхэлдэг, эрхлэх сонирхолтой 9 иргэн, аж ахуйн нэгж, "Төв түмний сүүн соёл -2023" арга хэмжээнд сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 5 иргэн, мах-ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйтай танилцах аялалд 9 иргэн, нийт 23 иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулан туршлага судлуулсан. "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт сургалтыг зохион байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж оролцуулсан. 2024 онд аймгийн хэмжээнд 141 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Үүнд: 21 иргэн мах, сүүний чиглэлийн 369 толгой үхэр, 18 иргэн махны чиглэлийн 954 толгой үхэр, 2 иргэн 261 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 25 иргэн 2189 толгой ноолуурын чиглэлийн ямаа, 5 иргэн 134 толгой гахай, 56 иргэн 1090 толгой шувуу, 12 иргэн 237 бүл зөгий, 2 иргэн 15 толгой туулайг тус тус өсгөн үржүүлж үйл ажиллагаагаа явуулж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран	
----------------------	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

										эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 66 хүнийг хамруулан өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн, өсгөн үржүүлэх болон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олон наст тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн түүхий эдээр дарш бэлтгэх арга технологийг эзэмшсэн. Төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэхэд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хариуцлагатай мал үржүүлэг технологийн хэлэлцүүлэг болон “ШИЛМЭЛ МАЛ-2024” үзэсгэлэн худалдаанд манай аймгаас 4 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож туршлага судалсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол үүлдрийн хуц-40 толгой өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан.	
9	8.5.4.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.	2020-2025	ХБТХО Х, ХХААГ	Орон нутгийн төсөв	8.0	2	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож, дэмжлэг үзүүлсэн байна.	8.5	Орон нутгийн төсөв 8.5 ХХСан 100.0 ЖДҮХС 697.5	2021-2022 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 5 иргэн, аж ахуйн нэгжид 332.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 онд Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. “Хоршоо хөгжүүлэх сан”-аас мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд 6 иргэнд 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. “Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо”-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Прогресс төслөөс 7.0 сая	100

									төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 10га талбайд ногоон тэжээл тариалж 30тн дарш, 2800 боодол ногоон тэжээл хураан авсан. 2024 онд “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд “хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр "Чиглэл" ХХК-д үйлдвэрлэгдсэн хүнсний зориулалтын савыг орон нутгийн сүү боловсруулах 2 үйлдвэр болон сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчин, фермерүүдэд дэмжлэг үзүүлсэн. Эрүүл ахуйн шаардлага хангасан сүүг малчдаас хүлээн авч сүүний үйлдвэрт нийлүүлснээр ард иргэдийг эрүүл аюулгүйн хүнсээр хангах боломж бүрдсэн. Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сангаас Мал аж ахуйн чиглэлээр “Арга билиг арвин сүрэг” ХХК хоршоонд 100 сая төгрөгийн зээл олгосон. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлэхээр Төмөрт Агро ХХК 200.0 сая/төг, Тэнүүн буянт ХХК 197.5 сая/төг, Сүүний үхэр өсгөн үржүүлэхээр Роял Алтай Констракшн ХХК 300.0 сая/төг нийт 3 ААН 697.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ										97.8%

НЭГТГЭСЭН:
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН МЭДЭЭ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ,

ПРОГРАММ СҮЛЖЭЭ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

О.ПҮРЭВЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА

Ж.БАЯРМАНДАХ